



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 02/23

Мөрөн

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 заалт, 26 дүгээр зүйлийн 26.2 заалт, Эрчим Хүчний зохицуулах хорооны 231 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал”, 2017 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифын саналыг хянах, шалгах журам”, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын засаг даргын 02/675 тоот тодорхойлолт, “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн ирүүлсэн хүсэлт, Хөвсгөл эрчим хүчний зохицуулах зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон төсөвт байгууллагуудын дулааны эрчим хүчний тарифыг хавсралтад зааснаар баталсугай.
2. Батлагдсан тарифыг 2023 оны 10 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн захирал /Д.Сүхбат/ - д зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн орон тооны гишүүн /Ч.Баярсайхан/-д даалгасугай.

ДАРГА

М.ХУЯГБААТАР

ГИШҮҮН


Ч.БАЯРСАЙХАН

ГИШҮҮН

Д.АЮУШЖАВ



Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн  
2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн  
02/23 тогтоолын хавсралт № 01



“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон  
төсөвт байгууллагын шинэчилсэн тариф

№	Байгууллага	ТЗЭ-ийн мөрдөж буй тариф	ТЗЭ-ээс ирүүлсэн тарифын санал 28%	ЭХЗЗ-ийн баталсан тариф 15%
1	Мөрөн 5 дугаар цэцэрлэг	1560	1997	1794
2	Мөрөн 9 дүгээр цэцэрлэг	1560	1997	1794
3	Мөрөн 12 дугаар цэцэрлэг	1560	1997	1794
4	Мөрөн 14 дүгээр цэцэрлэг	1560	1997	1794
5	Ирээдүй ЕБСургууль	1560	1997	1794
6	Мөрөн сум баг хөгжлийн төв	1560	1997	1794